## 3.1 Ажлын байр үйл ажиллагааны үндсэн цонхны тайлбар

## 3.1 Ажлын байр үйл ажиллагааны үндсэн цонхны тайлбар

Энэ дэд бүлэгт байгууллагын бүтцэд хамаарах ажлын байр, түүний орон тоог үүсгэх, засах, устгах зэрэг үйлдэл болон ажлын байрны бүртгэл цонхны бүтэц, ойлголтыг өгнө.

Хэсэг1 Ажлын байр үйл ажиллагааны үндсэн цонхны тайлбар

Хэсэг2 Ажлын байр шинээр үүсгэх үйл явцын зааварчилгаа

Хэсэг3 Ажлын байр засах үйл явцын зааварчилгаа

Хэсэг4 Ажлын байр устгах үйл явцын зааварчилгаа

Үйл ажиллагааны жагсаалтаас **ажлын байр**-ийг сонгоход дараах цонх нээгдэх бөгөөд энэ цонх нь харах төлөвтэй байна. Ажлын байр цонхны ерөнхий бүтэц нь зүүн дээд талд ажлын байрыг нэрээр хайх хайлтын талбар, баруун дээд хэсэгт ажлын байр үүсгэх, засах, устгах зэрэг үйлдлүүд, гол хэсэгт үүсгэсэн ажлын байрны жагсаалт хүснэгт хэлбэрээр байна.




| № | Ажлын байр | Дотоод бүтэц | Ажил | Байнгын/Түр | Ангилал | Зэрэглэл | Орон т | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цэвэрлэгч, албан байгууллагын | Захиргаа, аж... | Цэвэрлэгч, а... | Байнгын | ТҮ | ТҮ-1 | | | | |
| 2 | Нарийн мужаан | Захиргаа, аж... | Нарийн муж... | Байнгын | ТҮ | ТҮ-2 | | | | |
| 3 | Бичиг хэргийн бусад туслах ажилтан | Захиргаа, аж... | Бичиг хэргий... | Байнгын | ТҮ | ТҮ-2 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 4 | Жижүүр /байрны/ | Захиргаа, аж... | Жижүүр /бай... | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 3 | 3 | 0 | Идэвхтэй |
| 5 | Нийгмийн ажилтан, боловсролын | Захиргаа, аж... | Нийгмийн а... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 6 | Сантехникч, хоолой засварчин | Захиргаа, аж... | Сантехникч, ... | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 7 | Нярав, кассын | Захиргаа, аж... | Нярав, кассын | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 8 | Захирал, гүйцэтгэх захирал, ерөнхий б | Захиргаа, аж... | Захирал, гүй... | Байнгын | ТҮБД | ТҮБД-7 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 9 | Манаач, сахиул | Захиргаа, аж... | Манаач, сахиул | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 10 | Номын санч | Захиргаа, аж... | Номын санч | Байнгын | ТҮ | ТҮ-5 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 11 | Ерөнхий нягтлан бодогч | Захиргаа, аж... | Ерөнхий нягт... | Байнгын | ТҮ | ТҮ-8 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 12 | Их эмч, ерөнхий мэргэжлийн | Захиргаа, аж... | Их эмч, ерөн... | Байнгын | ТҮ | ТҮ-6 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 13 | Багш, монгол хэл, уран зохиолын | Сургалтын а... | Багш, монгол... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 6 | 6 | 0 | Идэвхтэй |
| 14 | Багш, бага ангийн /мэргэжлийн/ | Сургалтын а... | Багш, бага а... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 26 | 26 | 0 | Идэвхтэй |
| 15 | Багш, англи-орос хэлний | Сургалтын а... | Багш, англи-... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 16 | Багш, математикийн | Сургалтын а... | Багш, матем... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 6 | 6 | 0 | Идэвхтэй |
| 17 | Багш, мэдээлэл зүйн | Сургалтын а... | Багш, мэдээл... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 2 | 2 | 0 | Идэвхтэй |

Хуудас 1 - 2 (32 бичлэгээс 1 - 17) 1 2

Дараах хэсэгт ажлын байрны бүртгэл цонхны дэлгэрэнгүй тайлбарыг өгнө.

**Хайлт:**




Тайлбар: Дээд хэсэгт байрлах хайлтын талбарыг ажлын байрыг нэрээр хайхад ашиглана. Мөн дэлгэрэнгүй хайлт хэсэгт дарснаар ажлын байрыг нэр, ангилал, салбар-нэгж, газар-хэлтэс зэрэг дээрх талбаруудаар хайх боломжтой болно.

**Үйлдэл:**




Тайлбар: Энэ хэсэг нь салбар, нэгж, дотоод бүтцийн доор шинэ ажлын байр үүсгэх, засах, устгах үйлдлүүдийг хийнэ.

**Ажлын байрны мэдээлэл**




| № | Ажлын байр | Дотоод бүтэц | Ажил | Байнгын/Түр | Ангилал | Зэрэглэл | Орон тоо | Хүнтэй | Сул | Төлөв |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цэвэрлэгч, албан байгууллагын | Захиргаа, аж... | Цэвэрлэгч, а... | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 7 | 7 | 0 | Идэвхтэй |
| 2 | Нарийн мужаан | Захиргаа, аж... | Нарийн муж... | Байнгын | ТҮ | ТҮ-2 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 3 | Бичиг хэргийн бусад туслах ажилтан | Захиргаа, аж... | Бичиг хэргий... | Байнгын | ТҮ | ТҮ-2 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 4 | Жижүүр /байрны/ | Захиргаа, аж... | Жижүүр /бай... | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 3 | 3 | 0 | Идэвхтэй |
| 5 | Нийгмийн ажилтан, боловсролын | Захиргаа, аж... | Нийгмийн а... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 6 | Сантехникч, хоолой засварчин | Захиргаа, аж... | Сантехникч, ... | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 7 | Нярав, кассын | Захиргаа, аж... | Нярав, кассын | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 8 | Захирал, гүйцэтгэх захирал, ерөнхий б | Захиргаа, аж... | Захирал, гүй... | Байнгын | ТҮБД | ТҮБД-7 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 9 | Манаач, сахиул | Захиргаа, аж... | Манаач, сахиул | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 10 | Номын санч | Захиргаа, аж... | Номын санч | Байнгын | ТҮ | ТҮ-5 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 11 | Ерөнхий нягтлан бодогч | Захиргаа, аж... | Ерөнхий нягт... | Байнгын | ТҮ | ТҮ-8 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 12 | Их эмч, ерөнхий мэргэжлийн | Захиргаа, аж... | Их эмч, ерөн... | Байнгын | ТҮ | ТҮ-6 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 13 | Багш, монгол хэл, уран зохиолын | Сургалтын а... | Багш, монгол... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 6 | 6 | 0 | Идэвхтэй |
| 14 | Багш, бага ангийн /мэргэжлийн/ | Сургалтын а... | Багш, бага а... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 26 | 26 | 0 | Идэвхтэй |
| 15 | Багш, англи-орос хэлний | Сургалтын а... | Багш, англи-... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 16 | Багш, математикийн | Сургалтын а... | Багш, матем... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 6 | 6 | 0 | Идэвхтэй |
| 17 | Багш, мэдээлэл зүйн | Сургалтын а... | Багш, мэдээл... | Байнгын | ТҮБД | ТҮБД-4 | 2 | 2 | 0 | Идэвхтэй |

Тайлбар: Энэ хэсэгт ажлын байрны жагсаалтыг хүснэгт хэлбэрээр харуулна. Эхний баганад ажлын байрны нэр, дараагийн баганад тухайн ажлын байрны харьяалах дотоод бүтцийн нэгж, 3 дахь баганад тухайн ажлын байрны үндсэн ангилал, 4 дэх баганад тухайн ажлын байр нь байнгын эсвэл түр эсэх, дараагийн баганад тухайн ажлын байрны ангилал, зэрэглэл, 7-р баганад тухайн ажлын байрны орон тоо, 8, 9-р баганад ажлын байрны орон тоонд хэдэн хүн ажиллаж байгаа болон сул орон тоог, сүүлийн баганад тухайн ажлын байрны төлвийг харуулна.

---

### 3.2 Ажлын байр шинээр үүсгэх зааварчилгаа

Ажлын байр шинээр үүсгэх үйлдлийг хийхэд дараах алхамчилсан заавры дагуу хийнэ.

1. **Ажлын байр** модулийг сонгоно.
2. **Шинэ ажлын байр** үйлдлийг дарна
3. **Шинэ ажлын байр** бүртгэлийн цонхны мэдээллийг бүртгэнэ.
4. Бүртгэсэн мэдээллийг хадгална.

Ажлын байр модуль руу сонгоход дараах цонх нээгдэх бөгөөд баруун дээд хэсэгт байрлах **Шинэ ажлын байр** товчийг дарж шинэ ажлын байрыг бүртгэнэ.




| № | Ажлын байр | Дотоод бүтэц | Ажил | Байнгын/Түр | Ангилал | Зэрэглэл | Орон тоо | Хүнтэй | Сул | Төлөв |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сургалтын төлөвлөгөө боловсруулагч /Бусад/ | Сургалтын алба | Сургалтын төлөвл... | Байнгын | ТҮШУ | ТҮШУ-2 | 4 | 1 | 3 | Идэвхтэй |
| 2 | Дэд захирал, их сургуулийн | Захиргаа аж ахуй | Дэд захирал, их су... | Байнгын | ТҮ | ТҮ-2 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 3 | Багш, математикийн /ЕБС/ | Сургалтын алба | Багш, математик... | Байнгын | ТҮ | ТҮ-4 | 10 | 3 | 7 | Идэвхтэй |
| 4 | Сургалт хариуцсан мэргэжилтэн, сургуулийн өмнөх | Сургалтын алба | Сургалт хариуцса... | Байнгын | ТЗ | ТЗ-3 | 2 | 0 | 2 | Идэвхтэй |
| 5 | Захирал, гүйцэтгэх захирал, ерөнхий боловсролын | Захиргаа аж ахуй | Захирал, гүйцэтгэ... | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 9 | 1 | 8 | Идэвхтэй |
| 6 | Жолооч, машины | Захиргаа аж ахуй | Жолооч, машины | Байнгын | ТҮ | ТҮ-2 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 7 | Захирал, гүйцэтгэх захирал, дээд сургуулийн | Захиргаа аж ахуй | Захирал, гүйцэтгэ... | Байнгын | ТҮМБ | ТҮМБ-8 | 5 | 2 | 3 | Идэвхтэй |
| 8 | Дотоод ажил хариуцсан | Захиргаа аж ахуй | Менежер, дотоод ... | Байнгын | ТТ | ТТ-5 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 9 | Галч | Оюутан бүртгэлий... | Галч | Байнгын | ТҮ | ТҮ-1 | 9 | 0 | 9 | Идэвхтэй |
| 10 | Төсөв санхүүгийн мэргэжилтэн - Ерөнхий боловсро | Ажлын алба | Төсөв санхүүгийн ... | Байнгын | ТЗ | ТЗ-7 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 11 | Багшийн туслагч | Ажлын алба | Багшийн туслагч | Байнгын | ТҮБД | ТҮБД-3 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |
| 12 | Инноваци, өндөр технологийн газрын дарга | Ажлын алба | Дарга, яамны газ... | Байнгын | ТӨ | ТӨ-5 | 1 | 1 | 0 | Идэвхтэй |

**Шинэ ажлын байр үүсгэх** талбарыг дараалллын дагуу бүртгэж хадгалах товч дарснаар ажлын байр үүснэ.




**Ажлын мэдээлэл цонхны дэлгэрэнгүй тайлбар:**

**Ажлын мэдээлэл цонхны дэлгэрэнгүй тайлбар:**

| № | Талбар | Тайлбар | Жишээ |
|---|---|---|---|
| **Ажлын мэдээлэл** | | | |
| 1. | Салбар, нэгж | Үүсгэж байгаа ажлын байр харьяалах салбар, нэгжийг сонгоно | |
| 2. | Дотоод бүтэц | Үүсгэж байгаа ажлын байр харьяалах дотоод бүтцийг сонгоно. Өөрөөр хэлбэр шинэ ажлын байр нь ямар дотоод бүтцэд хамаарч байгааг харуулна. | Захиргаа аж ахуй |
| 3. | Ажлын ангилал | Ажлын байрны тохирох сонголтыг Хавсралт бүлгийн хүснэгт дэх 6 оронтой кодтой мөрийг харж сонгоно уу. ҮАМАТ-08 (ISCO-08) –аар оруулсан болно. Хайх товчин дээр дарснаар ажлын байрны ангиллыг сонгох цонх гарч ирнэ. Код, нэр талбаруудад тохирох утгуудыг бичиж хайх ба үр дүнгээс сонгон оруулна. | ЕБС-ын захирал, эрхлэгч |
| 4. | Ажлын байрны нэр | **Ажлын байрны нэр** талбарт **Ажлын байрны нэрийг** байгууллагын онцлогт тохируулан гараас оруулна. | Захирал |
| 5. | Орон тооны төрөл | Үүсгэж буй ажлын байрны орон тооны төрлийг сонгоно. | Ганцаар ажиллах |
| 6. | Орон тоо | Ажлын байрны орон тоог оруулна | 1 |
| 7. | Бүтэн цагийн тэнцэтгэл | Тухайн ажлын байрны ажлын цагийн тэнцэтгэлийг оруулна. | 1 |

---

### 3.3 Ажлын байр засах зааварчилгаа

Ажлын байрны мэдээлэл буруу бүртгэсэн тохиолдолд **менежер** системд өөрийн эрхээр нэвтэрч засах үйлдлийг хийнэ.

Ажлын байр засах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. **Ажлын байр** модулийг сонгоно.
2. Үндсэн цонхны ажлын байрны жагсаалтаас засах шаардлагатай ажлын байрны нэр дээр дарж засах цонх руу шилжих эсвэл засах ажлын байрыг идэвхжүүлнэ.
3. Үйлдлээс **Ажлын байр засах** цэсийг сонгоно.
4. **Ажлын байр засах** цонхны мэдээллийг бүртгэнэ.
5. Зассан мэдээллийг хадгална.

1. Хүний нөөцийн удирдлагын **ажлын байр** модуль руу орно.

Ажлын байрын жагсаалт дараах байдлаар харагдах бөгөөд баруун дээд буланд байрлах **үйлдэл** товчийг дарж ажлын байр засах цэсийг сонгоно.




2. Ажлын байр засах цэсний талбар дараах байдлаах харагдана.  Саарал дэвсгэртэй талбарууд засах боломжгүй зөвхөн дараах улаанаар тэмдэглэсэн хэсэгт засвар оруулах боломжтой.




---

### 3.4 Ажлын байр устгах үйл ажиллагааны зааварчилгаа

Ажлын байр буруу үүсгэсэн болон татан буугдсан ажлын байрыг менежер өөрийн эрхээр системд нэвтэрч устгах үйлдлийг хийнэ.

Ажлын байр устгах үйлдлийг хийхэд дараах алхамчилсан зааврын дагуу хийнэ.. Үүнд:

1. **Ажлын байр** үйл ажиллагааг сонгоно.
2. Үндсэн цонхны ажлын байрны жагсаалтаас устгах ажлын байрыг идэвхжүүлнэ.
3. Үйлдлээс **Ажлын байр устгах** гэснийг сонгоно.
4. Ажлын байрыг устгана.

1. Хүний нөөцийн удирдлагын А**жлын байр модуль** руу орно.

2. Ажлын байр модулийн баруун дээд хэсэгт байрлах үйлдэл дээр дарж ажлын байр устгах товчийг дарна.




Ажлын байр устгах асуулгын ТИЙМ товчийг дарснаар устгах үйлдэл амжилттай болно.




Хэрэв тухайн ажлын байранд хүн ажилд авч ажил эрхлэлт үүсгэсэн бол тухайн ажлын байрыг устгах боломжгүй гэсэн дараах дэд цонх нээгдэж анхааруулна.




**Санамж**: Ажлын байран дээр ажил эрхлэлт үүсч хүн ажилд авсан бол ажлын байрыг устгах боломжгүй байна. Энэ үед ажлын байран дээр үүсгэсэн ажил эрхлэлтийг цуцалсны дараа ажлын байрыг устгана.

---